



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.ЭРДЭНЭБАТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД**

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: letter@moe.gov.mn,
Цахим хуудас: www.moe.gov.mn

2026.06.04 № 01/3549

танай _____-ны № _____-т

Асуултын хариу хүргүүлэх тухай

Боловсролын салбарын багш, ажилчдын нийгмийн баталгааны талаар Улсын Их Хурлын гишүүний 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 27 тоот албан бичгээр ирүүлсэн асуулттай танилцлаа.

Асуулттай холбоотой дараах мэдээллийг хүргүүлж байна.

Нэг. Боловсролын салбарын багш, ажилчдын орон сууцны хөнгөлөлттэй зээл, 6 хувийн хүүтэй ипотекийн зээлд хамруулах талаар баримталж буй бодлого, хэрэгжилт, нийслэл болон орон нутгийн багш, ажилчдын хамрагдалтын тухайд:

Боловсролын салбарын албан хаагчдын орон сууцны хангамж, нөхцөл байдлын өнөөгийн түвшинг бодитой үнэлж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах зорилгоор 2025 оны 11 дүгээр сард салбарын 46,643 багш, ажилтныг хамруулсан судалгаа авсан. Уг судалгаанд хамрагдсан багш, ажилтны 53 хувь нь өөрийн өмчлөлийн орон сууцгүй, 88 хувь нь 2-3 өрөө орон сууцтай болох хүсэлттэй, 77 хувь нь 20 хүртэл сая төгрөгийг орон сууц худалдан авахад шаардлагатай урьдчилгаа өгөх боломжтой, сар бүр орон сууцны зээлд 500,000-800,000 төгрөг төлөх боломжтой гэж хариулсан байна.

Боловсролын сайд болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд байгуулдаг орон нутагт боловсролын салбарт хамтран ажиллах гэрээнд сүүлийн жилүүдэд "Мэргэжлийн багшийн хомсдолыг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцны болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх" асуудлыг тусган ажиллаж байна. Уг гэрээний дагуу 2025 оны 9 дүгээр сарын байдлаар 2024-2025 онуудад нийт 1,149 багш, ажилтан орон сууцны дэмжлэг аваад байна.

Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор "Төрийн өмчийн орон сууцыг иргэнд хөлслүүлэх, өмчлүүлэх журам" батлагдан хэрэгжиж эхэлсэн. Журмын дагуу нийслэл болон орон нутагт нийт квотын 20 хувьд төрийн үйлчилгээний албан хаагч (багш, эмч) нарыг хамруулахаар заасан. Орон сууцны сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан иргэний мэдээллийг Төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системээс авч байна.

1426111347

Хоёр. Хөдөө орон нутагт багшийн дутагдлыг бууруулах, шинээр томилогдон очиж буй багш нарыг тогтвортой ажиллуулах, суурьшуулах зорилгоор дээрхээс гадна орон нутгийн онцлогт тохируулан багш нарт зориулсан орон сууц барих, ашиглалтад оруулах чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ, хамрагдсан аймаг, сум, багш нарын тоон мэдээлэл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, мөн өндөр насны тэтгэвэрт гартал тогтвортой ашигласан багшид тухайн орон сууцыг нь өмчлүүлэх боломжтой эсэхийн тухайд:

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 192 дугаар тогтоолоор сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн "Багшийн гурван тулгуурт бодлого" цогц арга хэмжээ батлагдан хэрэгжиж байна.

Сургуулийн өмнөх боловсролд сүүлийн жилүүдэд мэргэжлийн багшийн хангалт нэмэгдэж, 93.5 хувьд хүрсэн боловч 1,443 багш дутагдалтай байсан. Цаашид сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдийн тоо буурч байгаатай холбоотойгоор багшийн хомсдол буурах төлөвтэй байна.

Ерөнхий боловсролын хувьд 2025-2026 оны хичээлийн жилд мэргэжлийн багшийн хангалт 97.0 хувь, нийслэлд 96.0, орон нутагт 97.2 хувьтай байна. 2025 оны 08 дугаар сарын байдлаар ерөнхий боловсролын сургуульд нийт 3,324 багшийн сул орон тоо байсан.

Энэ хичээлийн жилийн статистик мэдээгээр ерөнхий боловсролын сургуульд 2,742 багш дутагдалтай байгаагаас 1,290 нь орон нутагт байна. Хөтөлбөрийн шинэчлэл, ерөнхий боловсролын сургуулийн бүтцийн дахин төлөвлөлтэй холбоотойгоор багшийн дутагдлын тооцоолол хийгдэж байна.

Багш нарыг орон сууцаар хангах асуудал дээр дурдсан "Төрийн өмчийн орон сууцыг иргэнд хөлслүүлэх, өмчлүүлэх журам" болон Боловсролын сайд болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд байгуулдаг орон нутагт боловсролын салбарт хамтран ажиллах гэрээнд хүрээнд шийдвэрлэгдэж байгаа болно.

Гурав. Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр багш мэргэжлээр боловсон хүчин бэлтгэж буй их, дээд сургуулийн болон орон нутгийн багш нарыг гадаадын сургалт, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хамруулж байгаа эсэх, хамрагдсан багш нарын тоон мэдээллийн тухайд:

Засгийн газрын тусгай сангийн хуульд заасны дагуу Боловсролын зээлийн сан нь санхүүгийн дэмжлэг, тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох замаар дээд боловсрол эзэмших хүсэлтэй, тодорхой шалгуур, шаардлагыг хангасан иргэнийг төрөөс дэмжих бодлогыг хэрэгжүүлэх зориулалттай.

Боловсролын зээлийн сангаас 2025 онд дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад нийт 16,548 суралцагч, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад Засгийн газар хоорондын гэрээ, Засгийн газрын 346, 102, 215 дугаар тогтоолын дагуу Ерөнхийлөгч болон Засгийн газрын тэтгэлгээр 1,254 суралцагчид сургалтын төлбөрийн дэмжлэг, зээл олгосон.

Дөрөв. Суралцагчдыг IELTS болон олон улсын түвшний англи хэлний шалгалтад бэлтгэх мэргэжлийн болон арга зүйн чадамжтай баш нарын хүрэлцээ, цаашид энэ талаар баримтлах бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухайд:

Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 3,765 англи хэлний, 472 орос, англи хэлний багш ажиллаж байгаагаас төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд 3,062 англи хэлний, 454 орос, англи хэлний багш ажиллаж байна. Англи хэлний 367 багш дутагдалтай байгаа.

Монгол хэлний тухай хуульд төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаад хэлээр сургалт явуулдаг болон гадаад хэл заах тусгай зөвшөөрөл бүхий ерөнхий боловсролын сургуулиас бусад ерөнхий боловсролын сургуульд гадаад хэлийг тавдугаар ангиас эхлэн заахаар хуульчилсантай холбоотойгоор суралцагчид англи хэлийг 5 дугаар ангиас судалж ирсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангиас эхлэн англи хэлний ур чадварыг хөгжүүлэх сургалтыг нэвтрүүлэхээр заасан. Үүнтэй холбоотойгоор 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн 3, 4 ангид англи хэлийг нэмэлт хөтөлбөрөөр суралцаж эхлээд байна.

Ерөнхий боловсролд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн PEARSON хөтөлбөрийг ерөнхий боловсролын 3-8 дүгээр ангиудад хэрэгжиж байна. Цахим платформд суурилсан, интернэтгүй орчинд ашиглах, суралцагчийн гэрийн даалгавар, дасгал ажлыг системээр дамжуулан өгч, сурагчийн гүйцэтгэлийг бодит хугацаанд хянах боломжтой, бүрэн интерактив сурах бичиг, аудио, видео контентууд багтсан энэхүү цогц хөтөлбөрийг хэрэгжүүлдэг багшийг чадавхжуулах үйл ажиллагаа тогтмол хийгдэж байна. Уг хөтөлбөрийг улсын хэмжээнд 680 сургуулийн 3,450 багш хэрэгжүүлж байгаагаас 92 хувь нь англи хэлний багш, 2 хувийг нь бага ангийн багш нь хичээлээ зааж байна. Энэ хөтөлбөрөөр суралцсанаар суралцагчид 12 дугаар ангиа төгсөхдөө IELTS-ийн 7.5 оноотой төгсөх боломжтой.

Англи хэлний багш нарын чадавхыг бэхжүүлэх зорилгоор НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран, Монгол Улсын Боловсролын их сургуулийн дэргэд байгуулагдсан Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвөөр дамжуулан 8 аймгийн 781 англи хэлний багшийг хамруулсан сургалтын 2025, 2026 онд зохион байгуулсан.

Их Британийн зөвлөл (British Council)-тэй хамтран монголын англи хэлний багшийн чадамжийн хүрээний төслийг боловсруулаад байна. Чадамжийн хүрээ батлагдсанаар англи хэлний багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хүрээ, эзэмшсэн байх мэдлэг, чадвар тодорхой болох юм.

Тав. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын нийгмийн сүлжээ ашиглалтын талаарх судалгаа, цахим гэмт хэрэг, зөрчил, цахим дээрэлхэлт, гадуурхалтын хохирогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлд авч хэрэгжүүлсэн болон цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний тухайд:

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг цахим гэмт хэрэг, зөрчил, цахим дээрэлхэлт, гадуурхалтын хохирогч болохоос урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай

хамтран Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлгийг үе шаттай зохион байгуулж байна.

Хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн судалгаагаар ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа 13-аас дээш насны хүүхдийн 46 хувь нь өдөрт 2-4 цагийг цахим орчинд өнгөрүүлж байгаа бол 56 хувь нь “хүүхэд буруу зүйлд уруу татсан мэдээлэлтэй тааралдсан”, 22 хувь нь “хүүхэд заналхийлсэн, доромжилсон зурвас авч байсан” байсан бол судалгаанд хамрагдсан багш нарын 52.2 хувь нь “сурагчдад зан төлөвийн өөрчлөлт ашигласан, 45.2 хувь нь “сэтгэл зүйн асуудал ажигласан”, 42.1 хувь нь “цахим хэрэглээний донтолт ажигласан” гэж хариулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн сүлжээнд хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, аюулгүй байдлыг хангах, нийгмийн сүлжээний үйлчилгээнд хамаарах гомдол, мэдээлэл шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдэнэ.



Л.ЭНХ-АМГАЛАН